

Танилцуулга

“Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүнийг Монгол Улс, БНХАУ-д экспортлох, импортлох үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай Монгол Улсын МХЕГ болон БНХАУ-ын ЧХШХЦЕГ хоорондын протокол”-ыг 2011 онд байгуулсан.

Дээрх протоколын хүрээнд мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газартай хамтран хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:

1. БНХАУ-ын ЧХШХЦЕГ-ын ажлын хэсэгтэй хамтран 2014 оны 6 дугаар сарын 25-наас 7 дугаар сарын 5-ны өдрүүдэд Монгол Улсын 19 үйлдвэрт хянан магадалгааг хийж гүйцэтгэснээр “Мах маркет” ХХК, “Монгол эко мах” ХХК нь дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүн экспортлохоор БНХАУ-ын ЧХШХЦЕГ-ын Гэрчилгээ баталгаажуулалтын албанд бүртгүүлсэн.
2. Монгол, Хятадын хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд Газрын даргын түвшний ажлын хэсгийн 3 дахь, дэд сайдын түвшний 3 дахь уулзалтыг МХЕГ болон ХХААЯ-нд тус тус зохион байгуулж газрын даргын уулзалтсу 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулж 11 асуудал хэлэлцэж, дэд сайдын түвшний уулзалтаар 3 протоколд гарын үсэг зурж баталгаажуулав.
3. Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар болон БНХАУ-ын Чанарын Хяналт Шалгалт Хорио Цээрийн Ерөнхий Газар хооронд Монгол Улсаас БНХАУ-д адууны махан бүтээгдэхүүн экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээрийн хамтын ажиллагааны протоколыг 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Улаанбаатар хотноо МХЕГ-ын дарга Ш.Раднаасэд, БНХАУ-ын ЧХШХЦЕГ-ын дэд сайд У Цин Хай нар зурж баталгаажууллаа.
4. Баруун болон төвийн бүсийн шүлхий өвчний хоригийг цуцлах, мал төхөөрөх үйлдвэрүүдэд хянан магадалгааг БНХАУ-ын ЧХШХЦЕГ-ын экспертүүдтэй 2015 оны 9 дүгээр сарын 23-наас 10 дугаар сарын 4-ны өдрүүдэд хийсэн бөгөөд одоогоор хариу хараахан ирээгүй байна.
5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр “Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны махыг Монгол Улс, БНХАУ-д экспортлох, импортлох хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хамтын ажиллагааны тухай

Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, БНХАУ-ын Чанарын Хяналт, Шалгалт, Хорио Цээрийн Ерөнхий Газар хоорондын санамж бичиг”-ыг баталгаажуулснаар Монгол Улсаас БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүллээ.

Цаашид дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүн экспортлох аж ахуйн нэгж холбогдох баримт бичгээ манай байгууллагаар дамжуулан хятадын талд хүргүүлэх нь зүйтэй байна.

ХИЛ, ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР